



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 4 сарын 24 өдөр

Дугаар 64

Улаанбаатар хот

### Салбар нээх зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.2.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мөнх даатгал” ХХК-д Төв аймаг, Зуунмод сум, 1 дүгээр баг, “Хүүхэд залуучуудын хөгжлийн газар”-ын 1 дүгээр давхрын 1 тоотод, Хэнтий аймаг, Чингис хот, 2 дугаар баг, “Авто тээврийн төв”-ийн байранд, Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Харзат баг, Жанчивын гудамж, “Холбоо”-ны байр, 1 тоотод, Дорнод аймаг, Хэрлэн сум, 9 дүгээр баг, 62 дугаар байр, 21 тоотод тус бүр нэг, нийт 4 салбар нээх зөвшөөрөл олгосугай.

2. Салбар нээх зөвшөөрөл олгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Мөнх даатгал” ХХК /Т.Оюунгэрэл/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН